БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

БАЯНХОНГОР ҮЙЛДВЭРЖИЛТ ХӨГЖЛИЙН КОРПОРАЦЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Аудитын код: БНА-2021/8/СТА-ОНӨААН**

---

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2021 он


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584, 99007576

Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424, 99442140

Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Азбаяр

Утас: 99061429

Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn


---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга


1.Төрийн аудитын санал, дүгнэлт ... 3

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан... 5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ... 5

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан ... 6

3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан ... 7

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ... 8

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл ... 9

3.Аудитын тайлан ... 10

3.1. Ерөнхий зүйл ... 10

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ... 10

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт... 10

3.4. Материаллаг байдал ... 11

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ... 11

3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ... 12

3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа ... 14

3.8. Шилэн дансны мэдээлэл ... 14

3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ... 14

3.10. Аудитын илрүүлэлт ... 14

Залруулсан алдаа ... 14

4. Менежментийн захидал... 16

5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт... 17

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2021.03.15 № 2/181

танай ____________ -ны №____________ -т

БАЯНХОНГОР ҮЙЛДВЭРЖИЛТ
ХӨГЖЛИЙН КОРПОРАЦЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Н.БАЯРСАЙХАН ТАНАА

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорацын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорацын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90,0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,105,483,754.54** | **2,210,675,727.66** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **78,575,809.91** | **121,713,998.12** |
| **31100** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | **2,197,939.44** | **861,155.33** |
| 31110 | Төгрөг | 2,197,939.44 | 861,155.33 |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **76,377,870.47** | **120,852,842.79** |
| **31210** | **Төгрөг** | **76,377,870.47** | **120,852,842.79** |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 76,377,870.47 | 120,852,842.79 |
| **33** | **АВЛАГА** | **1,026,383,807.04** | **2,081,866,081.28** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 406,244.00 | 0 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 24,812,711.00 | 43,158,107.47 |
| 33401 | Дансны авлага /ТӨҮГ/ | 646,156.96 | 57,341.44 |
| **33600** | **Зээлийн авлага** | **1,000,518,695.08** | **2,038,650,632.37** |
| **33610** | **Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага** | **1,000,518,695.08** | **2,038,650,632.37** |
| 33612 | Хувь хүмүүст олгосон зээл | 1,000,518,695.08 | 2,038,650,632.37 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **524,137.59** | **7,095,648.26** |
| **35400** | **Хангамжийн материал** | **524,137.59** | **7,095,648.26** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 16,653.88 | 83,709.07 |
| 35420 | Аж ахуйн материал | 135,182.41 | 90,472.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 291,970.20 | 6,921,467.19 |
| 35450 | Барилгын засварын материал | 80,331.10 | 0 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,856,986,882.37** | **3,911,473,562.89** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **2,856,986,882.37** | **3,911,473,562.89** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **2,745,276,882.37** | **3,800,263,562.89** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,866,619,843.33 | 4,099,386,638.33 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -246,194,692.79 | -406,254,985.52 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 85,078,751.58 | 87,042,387.94 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -23,104,823.26 | -41,166,835.69 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 20,490,090.00 | 20,879,090.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -2,615,666.49 | -4,626,112.17 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 45,003,380.00 | 45,003,380.00 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **111,710,000.00** | **111,210,000.00** |
| 39301 | Програм хангамж | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -250,000.00 | -750,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 110,960,000.00 | 110,960,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,962,470,636.91** | **6,122,149,290.55** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,153,171,433.26** | **2,243,710,623.62** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **75,777,433.26** | **131,855,123.62** |
| **41300** | **Өглөг** | **14,422,513.26** | **24,066,130.02** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 0 | 62,169.00 |
| **41360** | **Бусад өглөг** | **14,422,513.26** | **24,003,961.02** |

| | | | |
|---|---|---|---|
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 11,735,211.10 | 16,716,983.80 |
| 41363 | Татварын өглөг /ТӨҮГ/ | 2,687,302.16 | 7,131,697.22 |
| 41366 | Дансны өглөг /ТӨҮГ/ | 0 | 155,280.00 |
| **41400** | **Урьдчилж орсон орлого** | **61,354,920.00** | **107,788,993.60** |
| 41440 | Бусад урьдчилж орсон орлого | 61,354,920.00 | 107,788,993.60 |
| **42** | **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **1,077,394,000.00** | **2,111,855,500.00** |
| **42200** | **Урт хугацаат зээл** | **1,077,394,000.00** | **2,111,855,500.00** |
| **42210** | **Төгрөг** | **1,077,394,000.00** | **2,111,855,500.00** |
| 42212 | Хувь хүмүүсийн зээл | 1,077,394,000.00 | 2,111,855,500.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,809,299,203.65** | **3,878,438,666.93** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **2,809,299,203.65** | **3,878,438,666.93** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 3,099,420,127.36 | 4,332,186,922.36 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **-290,120,923.71** | **-453,748,255.43** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -88,455,424.73 | -165,027,331.72 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -201,665,498.98 | -288,720,923.71 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,962,470,636.91** | **6,122,149,290.55** |

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **118,031,544.65** | **173,147,036.37** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **118,031,544.65** | **173,147,036.37** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **118,031,544.65** | **173,147,036.37** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **118,031,544.65** | **173,147,036.37** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 34,031,544.65 | 93,147,036.37 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 84,000,000.00 | 80,000,000.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **319,697,043.63** | **461,867,960.08** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **319,697,043.63** | **461,867,960.08** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **319,697,043.63** | **461,867,960.08** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **319,697,043.63** | **461,867,960.08** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 146,246,466.07 | 281,235,209.24 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 173,450,577.56 | 180,632,750.84 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **-201,665,498.98** | **-288,720,923.71** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **-201,665,498.98** | **-288,720,923.71** |

## 3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,023,983,717.36** | **0** | **-88,455,424.73** | **2,935,528,292.63** |
| **2** | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **0** | **0** | **0** | **0** |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **3,023,983,717.36** | **0** | **-88,455,424.73** | **2,935,528,292.63** |
| **4** | **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт** | **0** | **0** | **0** | **0** |
| **5** | **Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт** | **75,436,410.00** | **0** | **0** | **75,436,410.00** |
| **6** | **Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз** | **0** | **0** | **0** | **0** |
| **7** | **Өмчид гарсан өөрчилөлт** | **0** | **0** | **0** | **0** |
| **8** | **Зарласан ногдол ашиг** | **0** | **0** | **0** | **0** |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | **0** | **0** | **-201,665,498.98** | **-201,665,498.98** |
| **10** | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,099,420,127.36** | **0** | **-290,120,923.71** | **2,809,299,203.65** |
| **11** | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **3,099,420,127.36** | **0** | **-290,120,923.71** | **2,809,299,203.65** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0 | 1,400,000.00 | 1,400,000.00 |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **3,099,420,127.36** | **0** | **-288,720,923.71** | **2,810,699,203.65** |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0 | 0 | 0 | 0 |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 1,232,766,795.00 | 0 | 0 | 1,232,766,795.00 |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0 | 0 | 0 | 0 |
| 17 | Өмчид гарсан өөрчилөлт | 0 | 0 | 0 | 0 |
| 18 | Зарласан ногдол ашиг | 0 | 0 | 0 | 0 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | -288,720,923.71 | -288,720,923.71 |
| **20** | **2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **4,332,186,922.36** | **0** | **-453,748,255.43** | **3,878,438,666.93** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **552,302,154.70** | **1,210,139,772.07** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **552,302,154.70** | **1,210,139,772.07** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **552,302,154.70** | **1,210,139,772.07** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **552,302,154.70** | **1,210,139,772.07** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 452,046,154.70 | 792,659,772.07 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 100,256,000.00 | 417,480,000.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **596,631,426.81** | **1,164,648,947.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **596,631,426.81** | **1,164,648,947.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **546,631,426.81** | **1,155,233,946.48** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **546,631,426.81** | **1,155,233,946.48** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 546,631,426.81 | 1,155,233,946.48 |
| **212** | **ТАТААС** | **50,000,000.00** | **9,415,001.02** |
| **2122** | **Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас** | **50,000,000.00** | **9,415,001.02** |
| 212201 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 50,000,000.00 | 9,415,001.02 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **-44,329,272.11** | **45,490,824.57** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **2,527,454.55** | **2,352,636.36** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,527,454.55** | **2,352,636.36** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **2,527,454.55** | **2,352,636.36** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,527,454.55 | 2,352,636.36 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-2,527,454.55** | **-2,352,636.36** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **-46,856,726.66** | **43,138,188.21** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 125,432,536.57 | 78,575,809.91 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 78,575,809.91 | 121,713,998.12 |

## 2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөг/

| д/д | Зардлын нэр | 2019 оны гүйцэтгэл | 2020 оны төлөвлөгөө | 2020 оны гүйцэтгэл | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Цалин | 67,738.0 | 97,560.0 | 93,007.1 | 95.3 |
| 2 | ЭМД, НДШ | 8,336.4 | 11,970.0 | 23,805.0 | 198.9 |
| 3 | Цахилгааны зардал | 12,515.8 | 19,743.7 | 12,523.1 | 63.4 |
| 4 | Нүүрсний зардал | 3,124.3 | 2,871.0 | 3,746.8 | 130.5 |
| 5 | Тээврийн зардал | 1,712.0 | 3,213.0 | 741.8 | 23.1 |
| 6 | Халаалт | 10,648.5 | 30,404.4 | 21,322.6 | 70.1 |
| 7 | Цэвэр бохир усны зардал | 180.4 | 9,342.3 | 1,139.3 | 12.2 |
| 8 | Засвар үйлчилгээний зардал | 2,714.0 | 2,640.0 | - | - |
| 9 | элэгдлийн зардал | 173,450.5 | 180,284.0 | 180,132.8 | 99.9 |
| 10 | Ариутгал Цэвэрлэгээ | 811.9 | 773.3 | 2,035.1 | 263.2 |
| 11 | Гамшгийн нөөцийн зардал | 111.9 | 740.5 | - | - |
| 12 | БГАҮ | 3,154.0 | 800.0 | 947.5 | 118.4 |
| 13 | Хөдөлмөр хамгаалал | 311.8 | 1,951.3 | 1,112.4 | 57.0 |
| 14 | Бичиг хэрэг | 1,267.1 | 2,331.5 | 1,469.1 | 63.0 |
| 15 | Шуудан холбоо | 688.6 | 1,200.0 | 1,089.9 | 90.8 |
| 16 | Шатахуун | 1,544.8 | 1,815.0 | 2,049.7 | 112.9 |
| 17 | Урсгал засвар | 1,741.8 | 262.0 | 976.1 | 372.6 |
| 18 | Сэлбэгийн зардал | 811.0 | 900.0 | 727.1 | 80.8 |
| 19 | Бусад зардал | 1,114.9 | 1,114.9 | 30,011.1 | 2,690.9 |
| 20 | ТУЗ-ын урамшуулал | 182.0 | 5,164.0 | 2,891.3 | 56.0 |
| 21 | Албан томилолт | 370.0 | 1,500.0 | - | - |
| 22 | Шагнал | 170.0 | 200.0 | - | - |
| 23 | тэтгэмж | - | - | 2,140.0 | - |
| | Үйл ажиллагааны дүн | **292,699.7** | **376,780.9** | **381,868.0** | 0.1 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорацын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг гүйцэтгэх захирал Н.Баярсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд зээлийн эргэн төлөлтийн авлагын талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 05-наас 20.. оны 03 дугаар сарын 15–ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорацын 2020 оны санхүүгийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 02 дугаар сарын 14-ний өдөр ирүүлсэн байна.

Тус байгууллагын санхүүгийн гүйлгээнд хөрөнгө мөнгийг зарцуулахдаа 1-р гарын үсгийг гүйцэтгэх захирал 2020.01.01-2020.07.29 хүртэл С.Батцэрэн, 2020.07.29-өөс он дуустал Н.Баярсайхан, 2-р гарын үсгийг 2020.01.01-2020.09.25 хүртэл нягтлан бодогч В.Наранцэцэг 2020.09.25-ноос он дуустал А.Одгэрэл нар гарын үсэг зурж үйл ажиллагаа явуулсан байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд “Хязгаарлагдмал хариуцлагатай компани” гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг орон нутгийн өмч эзэмшиж байна.

Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорацын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Жижиг дунд үйлдвэр, хөдөө аж ахуй, газар тариалан эрхлэгчдийг сургах, хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэх, холбон зуучлах, удирдлага арга зүйгээр ханган ажиллах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд тус байгууллагын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийгдээгүй байна.

Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорацын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт хөрөнгийг сонгож, эрсдэлийн төвшнийг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1,0 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын төвшнийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 6122149,3 мянган төгрөгөөс 1,0 хувиар буюу 61221,5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон. Гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорацын 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2159678,7 мянган төгрөгөөр буюу 54,5 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/Мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 1,105,483.8 | 2,210,675.7 | 1,105,192.0 |
| Мөнгөн хөрөнгө | 78,575.8 | 121,714.0 | 43,138.2 |
| Авлага | 1,025,977.6 | 2,081,866.1 | 1,055,888.5 |
| Урьдчилгаа | 406.2 | - | (406.2) |
| Бараа материал | 524.1 | 7,095.6 | 6,571.5 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,856,986.9 | 3,911,473.6 | 1,054,486.7 |
| Үндсэн хөрөнгө | 3,129,152.1 | 4,364,271.5 | 1,235,119.4 |
| Хуримтлагдсан элэгдэл | (272,165.2) | (452,797.9) | (180,632.8) |
| **Нийт хөрөнгө** | 3,962,470.6 | 6,122,149.3 | 2,159,678.7 |
| Өр төлбөр | 1,153,171.4 | 2,243,710.6 | 1,090,539.2 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 2,809,299.2 | 3,878,438.7 | 1,069,139.5 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 3,962,470.6 | 6,122,149.3 | 2,159,678.7 |

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 121714,0 мянган төгрөг болж 43138,2 мянган төгрөгөөр өссөн байна.

| № | Он | Зээлдэгчийн тоо | Зээлийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | 2012-2016 | 26 | 377361,5 |
| 2 | 2017 | 12 | 238027,9 |
| 3 | 2018 | 25 | 278241,6 |
| 4 | 2019 | 21 | 210820,0 |
| 5 | 2020 | 56 | 920723,8 |
| | нийт | 140 | 2037418,1 |

Авлага дансны үлдэгдэл 2081866,1 мянган төгрөг болж 1055888,5 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн нь 2020 онд 940000,0 мянган төгрөгийн зээл нэмж олгосон бөгөөд 2012-2016 онд олгосон зээлийн 429361,5 мянган төгрөгийн зээлийг аймгийн ЗДТГ-аас тус байгууллагад шилжүүлсэнтэй холбоотой байна.

Нийт авлагаас 429361,5 мянган төгрөг нь насжилт ихтэй эрсдэлтэй авлага байна. Энэ нь цаашид найдваргүй авлага үүсэх үр дагавартай байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 7095,6 мянган төгрөг болж 6571,5 мянган төгрөгөөр өссөн нь хангамжийн материалын данс өссөн нь шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4364271,5 мянган төгрөг болж мянган 1235119,4 мянган төгрөгөөр өссөн нь барилга байгууламжийн данс нэмэгдсэн нь шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1232766,8 мянган төгрөгийн "Ахуйн үйлчилгээний барилга"-ыг аймгийн ИТХ-ын 2020 оны 48 дугаар тогтоолоор үнэ төлбөргүй шилжүүлсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2243710,6 мянган төгрөг болж 1090539,25 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгаас 2020 онд нэмж шийдвэрлэсэн 480000,0 мянган төгрөг, зээлийн батлан даалтын сангийн 50000,0 мянган төгрөг, хас банкны үлдэгдэл 75000,0 мянган төгрөг, 2016-2020 оны зээлийн 429361,5 мянган төгрөг, түрээсийн барьцаа 6338,7 мянган төгрөгийг урьдчилж орсон орлогоор бүртгэсэнтэй холбоотой байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 4220427,9 мянган төгрөг болж 1232766,8 мянган төгрөгөөр өссөн нь ахуйн үйлчилгээний барилгыг бүртгэж авсантай холбоотой . Энэхүү өмчийн бүртгэд нь төрийн өмчийн хэсэгт бүртгэгдсэн байна.

Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг -453748,3 сая төгрөг болж 165027,3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд алдагдалтай ажилласнаас шалтгаалжээ.

## 3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорацын гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, ТУЗ-өөр батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Тайлант оны нийт орлогыг 202916,2 мянган төгрөгөөр, нийт зардлыг 384280,9 мянган төгрөгөөр, алдагдлыг 181364,7 мянган төгрөгөөр тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд зардал төлөвлөөгүй байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг алдагдалтай баталсан гол шалтгаан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 180284,0 мянган төгрөгөөр тооцсон бөгөөд одоогийн үйл ажиллагааны зардал нь шууд зардлын түвшинд байгаа бөгөөд элэгдлийн өртгийг үйлчилгээний төлбөрт оруулаагүйтэй холбоотой байна.

Гүйцэтгэлээр 173147,2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 461868,0 мянган төгрөгийн зардал гарган, 228720,9 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. 3

Орлогын эх үүсвэр нь "Ажилсаг төв" болон "Ахуйн үйлчилгээний төв"-ийн түрээсийн орлогоос бүрджээ.

Хүснэгт 1. 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин /Мянган төгрөгөөр/

| д/д | Үзүүлэлт | | 2019 оны гүйцэтгэл | 2020 оны төлөвлөгөө | 2020 оны гүйцэтгэл | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Санхүүгийн дэмжлэг | | 0 | 80,000.0 | 80,000.0 | 100.0 |
| 2 | Төсөл хөтөлбөр | | 1,257.5 | 1,500.0 | - | - |
| 3 | Түрээсийн орлого | Ажилсаг төв | 53,084.7 | 47,204.3 | 47,366.2 | 100.3 |
| | | Ахуйн үйлчилгээний төв | 6,249.0 | 51,592.0 | 45,780.8 | 88.7 |
| | | Бусад | 23,408.8 | - | | - |
| 4 | | Дүн | 84,000.0 | 180,296.3 | 173,147.0 | 96.0 |

Хүснэгт 2. 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин /Мянган төгрөгөөр/

| д/д | Зардлын нэр | 2019 оны гүйцэтгэл | 2020 оны төлөвлөгөө | 2020 оны гүйцэтгэл | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Цалин | 67,738.0 | 97,560.0 | 93,007.1 | 95.3 |
| 2 | ЭМД, НДШ | 8,336.4 | 11,970.0 | 23,805.0 | 198.9 |
| 3 | Цахилгааны зардал | 12,515.8 | 19,743.7 | 12,523.1 | 63.4 |
| 4 | Нүүрсний зардал | 3,124.3 | 2,871.0 | 3,746.8 | 130.5 |
| 5 | Тээврийн зардал | 1,712.0 | 3,213.0 | 741.8 | 23.1 |
| 6 | Халаалт | 10,648.5 | 30,404.4 | 21,322.6 | 70.1 |
| 7 | Цэвэр бохир усны зардал | 180.4 | 9,342.3 | 1,139.3 | 12.2 |
| 8 | Засвар үйлчилгээний зардал | 2,714.0 | 2,640.0 | - | - |
| 9 | элэгдлийн зардал | 173,450.5 | 180,284.0 | 180,132.8 | 99.9 |
| 10 | Ариутгал Цэвэрлэгээ | 811.9 | 773.3 | 2,035.1 | 263.2 |
| 11 | Гамшгийн нөөцийн зардал | 111.9 | 740.5 | - | - |
| 12 | БГАҮ | 3,154.0 | 800.0 | 947.5 | 118.4 |
| 13 | Хөдөлмөр хамгаалал | 311.8 | 1,951.3 | 1,112.4 | 57.0 |
| 14 | Бичиг хэрэг | 1,267.1 | 2,331.5 | 1,469.1 | 63.0 |
| 15 | Шуудан холбоо | 688.6 | 1,200.0 | 1,089.9 | 90.8 |
| 16 | Шатахуун | 1,544.8 | 1,815.0 | 2,049.7 | 112.9 |
| 17 | Урсгал засвар | 1,741.8 | 262.0 | 976.1 | 372.6 |
| 18 | Сэлбэгийн зардал | 811.0 | 900.0 | 727.1 | 80.8 |
| 19 | Бусад зардал | 1,114.9 | 1,114.9 | 30,011.1 | 2,690.9 |
| 20 | ТУЗ-ын урамшуулал | 182.0 | 5,164.0 | 2,891.3 | 56.0 |
| 21 | Албан томилолт | 370.0 | 1,500.0 | - | - |
| 22 | Шагнал | 170.0 | 200.0 | - | - |
| 23 | тэтгэмж | - | - | 2,140.0 | - |
| | Үйл ажиллагааны дүн | **292,699.7** | **376,780.9** | **381,868.0** | 0.1 |

Нийт орлогын гүйцэтгэл 93047,0 мянган төгрөг болж төлөвлөснөөс 5649,2 мянган төгрөг буюу 94,5 хувиар тасарсан нь түрээсийн талбай зарим саруудад түрээслэгч байхгүй байснаас шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 381868,0 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 5087,1 мянган төгрөг буюу 101,4 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь ЭМНДШ-ийг дутуу төлөвлөсөн, ариутгал цэвэрлэгээний зардал болон бусад зардал төлөвлөснөөс илүү гарсантай холбоотой байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу нийт 9 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2020 онд 2 удаа зохион байгуулж 2 асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

2020 онд ТУЗ-ийн үйл ажиллагааны зардалд нийт 5164,0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 935,0 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн нь урамшууллын зардал байна.

### 3.8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 101 мэдээллээс 57 мэдээллийг хугацаанд нь, 16 мэдээллийг хугацаа хоцроож, 28 мэдээллийг байршуулаагүй байна.

### 3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.

*Хүснэгт 2.* Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | 1 | 220,0 | 1 | 220,0 | 100 |
| Зөвлөмж | 2 | 7,5 | 2 | 7,5 | 100 |
| Нийт дүн | 3 | 227,5 | 3 | 227,5 | 100 |

### 3.10. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 255097,1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 26993,4 мянган төгрөгийн алдааг залруулж, 228103,7 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож залруулга хийсэн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Аймгийн ИТХ-ын шийдвэрээр 2012-2016 онд олгосон зээлийн 461855,5 мянган төгрөгийн зээлийн үлдэгдлийг тус газрын санхүүгийн тайланд тусгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд ҮХК-д шилжихээс өмнө 32394,0 мянган төгрөгийн орон нутгийн орлогод тушааж, 429461,5 авлагыг тусгахаар шилжсэн боловч 12243,4 мянган төгрөгөөр дутуу тусгасан , мөн 2020 онд олгосон зээлээс 14750,0 мянган төгрөгийн авлагыг дутуу тусгасан тул санхүүгийн тайланд залруулав.

**Төлбөрийн акт, албан шаардлага**

1. 2020 оны жилийн эцсийн байдлаар 140 иргэний 2037418,1 мянган төгрөгийн зээлийн авлагатайгаас хугацаа хэтэрсэн боловч ямар нэгэн арга хэмжээ аваагүй, зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн 45 иргэний 228103.7 мянган төгрөгийн зээл эргэн төлөгдөөгүй байгаа нь Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 13.2.8-т заасан "Сангаас олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, зээлийн гэрээний үүргээ биелүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн, Эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u>

Хугацаа хэтэрсэн 228103,7 мянган төгрөгийн зээлийг эргэн төлүүлэх, төлөөгүй тохиолдолд хуулийн байгууллагад шилжүүлэн асуудлыг шийдвэрлэх төлбөрийн акт тогтоов.

2. Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 101 мэдээллээс 57 мэдээллийг хугацаанд нь, 16 мэдээллийг хугацаа хоцроож, 28 мэдээллийг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1-д заасан "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u>

Цахим сайтад мэдээллийг бүрэн байршуулах зөвлөмж өгөв.

3.11. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

1. ЖДҮ-ээс олгосон зээлийн хэрэгжилт, эргэн төлөлт шалгах
2. Түрээсийн талбайн ашиглалтын гэрээний хэрэгжилт
3. Санхүүгийн алдагдал бууруулах талаар удирдлагаас зохион байгуулсан арга хэмжээ, түүний гүйцэтгэл

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

***1.1. Илрүүлэлт:***

Аймгийн ИТХ-ын шийдвэрээр 2012-2016 онд олгосон зээлийн 461855,5 мянган төгрөгийн зээлийн үлдэгдлийг тус газрын санхүүгийн тайланд тусгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд ҮХК-д шилжихээс өмнө 32394,0 мянган төгрөгийн орон нутгийн орлогод тушааж, 429461,5 авлагыг тусгахаар шилжсэн боловч 12243,4 мянган төгрөгөөр дутуу тусгасан , мөн 2020 онд олгосон зээлээс 14750,0 мянган төгрөгийн авлагыг дутуу тусгасан ба тус байгууллага нь зээлдэгч нартай зээлийн үлдэгдлийг баталгаажуулж гэрээ байгуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-т заасан “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***1.2. Эрсдэл:***

Төрийн өмч эзэнгүйдэх үргүй зарцуулагдах

***1.3. Өгсөн зөвлөмж***

Нягтлан бодох бүртгэлд тусгах өглөг, авлагатай холбоотой шийдвэр, гэрээ, бусад баримт бичигт тулгуурлан тооцоо нийлсэн акт үйлдэж, санхүүгийн тайланд үнэн зөв тусгаж, үлдэгдлийг анх авсан тооцооноос эхлэн бүртгэж бүрэн баталгаажуулах.

***1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:***

Хүлээн зөвшөөрсөн

2. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

*2.1.* ***Илрүүлэлт:***

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 101 мэдээллээс 57 мэдээллийг хугацаанд нь, 16 мэдээллийг хугацаа хоцроож, 28 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1-д заасан "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

*2.2.* ***Эрсдэл:***

Шилэн дансны хууль зөрчигдөх

*2.3.* ***Өгсөн зөвлөмж***

Цахим сайтад мэдээллийг бүрэн байршуулж, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1-д заасан "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

*2.4.* ***Байгууллагаас өгсөн хариу тайлбар:***

Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР: Б.АЗБАЯР 2021.03.15

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЭНЯМ 2021.03.15

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ 2021.03.15

## 5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорацын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2020 | | | БНА-2021/8/СТА-ОНӨААН |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | **Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци** | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | 2020 оны жилийн эцсийн байдлаар 2072318,7 мянган төгрөгийн зээлийн авлагатайгаас хугацаа хэтэрсэн боловч ямар нэгэн арга хэмжээ аваагүй, зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн 228103.7 мянган төгрөгийн зээл эргэн төлөгдөөгүй байна. | 228103,7 | Төлбөрийн акт тогтоох | Гүйцэтгэх захирал, Нягтлан бодогч | Н.Баярсайхан, А.Одгэрэл |
| 2 | Аймгийн ИТХ-ын шийдвэрээр 2012-2016 онд олгосон зээлийн 461855,5 мянган төгрөгийн зээлийн үлдэгдлийг тус газрын санхүүгийн тайланд тусгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд ҮХК-д шилжихээс өмнө 32394,0 мянган төгрөгийн орон нутгийн орлогод тушааж, 429461,5 авлагыг тусгахаар шилжсэн боловч 12243,4 мянган төгрөгөөр дутуу тусгасан , мөн 2020 онд олгосон зээлээс 14750,0 мянган төгрөгийн авлагыг дутуу тусгасан байна. | 26994,4 | Санхүүгийн тайланд залруулж, цаашид алдаа давтан гаргахгүй байх зөвлөмж өгөх | Гүйцэтгэх захирал, Нягтлан бодогч | Н.Баярсайхан, А.Одгэрэл |
| 3 | Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 101 мэдээллээс 57 мэдээллийг хугацаанд нь, 16 мэдээллийг хугацаа хоцроож, 28 мэдээллийг байршуулаагүй байна. | 0 | Зөвлөмж өгөх | Гүйцэтгэх захирал, Нягтлан бодогч | Н.Баярсайхан, А.Одгэрэл |
| **ДҮН** | | **255097,1** | | | |